



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/41

Шивээговь сум

Газар ашиглах эрхийн зориулалтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2021 оны А/187 дугаар “Журам батлах тухай” тушаалын 5.1.3.5, 8.1.9 дэхь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр “Сумын газар зохион байгуулалтын 2024 оны тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр газар тусгах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1.Превалент ГХОХХК нь Шивээговь сумын Бэхт баг, Шивээ-Овоо хувьцаат компанийн уурхайн хойд талд байрлах “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын зориулалттай 30 га газрынхаа газар ашиглах эрхийн зориулалтад өөрчлөлт оруулах хүсэлт гаргасны дагуу зориулалтыг “Үйлдэрлэлийн барилга байгууламж, бусад газар болгон өөрчилж, 5 жилийн хугацаатай ашиглуулсугай.

2.Хуулийн дагуу ашиглаж буй газрынхаа орчныг эрүүл, хог хаягдалгүй байлгаж, экологийн тэнцвэрт байдлыг хангаж, ногоон байгууламжийг бий болгон Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг Превалент ГХОХХК-ийн гүйцэтгэх захирал (Ганболдын Номуун)-д үүрэг болгосугай.

3.Газар ашиглагч Превалент ГХОХХК-ийн гүйцэтгэх захирал Ганболдын Номуунтай газар ашиглах гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/27 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42124 092